

Санхүүгийн хяналт шалгалт
хийсэн дүнгийн тухай

НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Булган аймгийн Засаг даргын баталсан 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 1/21 тоот удирдамжийн хүрээнд Могод сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд Монгол Улсын санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн 69.1-д / Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тотоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдлийн удирлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна./ заалт болон “Дотоод аудитын албаны дүрэм” зэргийг үндэслэн тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгаж, шалгалтаар илэрсэн дутагдал зөрчлийг арилгах, засч залруулахад оршино.

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч А.Анхбаяр 2022 оны 11 сарын 14-ний өдрөөс хуанлийн 6 хоногт багтаан хяналт шалгалтыг хийж гүйцэтгэв.

ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Могод сумын ИТХ, Засаг даргын тамгын газрын 2021 оны касс, харилцах дансны гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгасны зэрэгцээ албан томилолтын бодолт, олголт, бараа материалын худалдан авалт, зарцуулалт, үлдэгдлийн байдал, нэмэлт орлого түүний бүрдүүлэлт, зарцуулалт, шатахууны олголт, зарцуулалт, хэтрэлт хэмнэлт, эд хөрөнгийн тооллого тооцоо бодолт, санхүү, төсвийн ил тод байдлын хэрэгжилт, “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлуудыг хамрууллаа.

ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ

ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Булган аймгийн Могод сумын ИТХ нь 3 ажилтантай ба үүнээс удирдах 1, гүйцэтгэх 2, мөн багийн иргэдийн нийтийн хурлын дарга 4 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

ЗДТГ нь 24 ажиллагсадтай ба үүнээс удирдах 3, гүйцэтгэх ажилтан 11, үйлчилгээний албан хаагч 7, багийн засаг дарга 3 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

ИТХ-ын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд нэгдүгээр гарын үсгийг 2021 оны 01 сарын 01-ээс 2021 оны 12 сарын 20-ны өдрийг дуустал Н.Халтар, 2021 оны 12 сарын 20-ноос 12 сарын 31-ний өдрийг хүртэл Г.Энхбат, хоёрдугаар гарын үсгийг 2021 оны 01 сарын 01-нээс 2021 оны 12 сарын 31-ний өдрийг дуустал нягтлан бодогч Э.Чинзориг нар зурсан ба төрийн санд бүртгэлтэй 100040654001 тоот данс, нэмэлт санхүүжилтийн 100040654401 тоот дансаар хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан байна.

Засаг даргын тамгын газрын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд нэгдүгээр гарын үсгийг 2021 оны 01 сарын 01-нээс 2021 оны 01 сарын 31-ний өдрийг хүртэл О.Эрдэнэчимэг, 2021 оны 02 сарын 01-нээс 2021 оны 12 сарын 31-ний өдрийг дуустал Х.Мөнх-Алтай, хоёрдугаар гарын үсгийг 2021 оны 01 сарын 01-нээс 2021 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэл Э.Чинзориг нар зурсан ба төрийн санд бүртгэлийн 100040655001 тоот данс, нэмэлт санхүүжилтийн 100040655405 тоот, дансаар хөрөнгө мөнгийг захиран зарцуулж ирсэн ба нягтлан бодох бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн STS программаар бүртгэн хөтөлжээ.

Шалгагдсан онуудад нярав, эд хариуцагчаар Л.Отгончимэг ажилласан байна.

ТАВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Аймгийн Аудитын газраас ИТХ-ын 2021 оны тайлан баталгаажуулалтаар түүвэр судалгаанд хамруулсан байна.

Булган аймаг дахь Төрийн аудитын газраас 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийж **зөрчилгүй** санал дүгнэлт өгсөн байна.

2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 10,078.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 9,478,8 мянган төгрөгийн алдааг залруулж, 600,0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн байна.

ЗУРГАА. ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Могод сумын ИТХ нь шилэн дансны shilendans.gov.mn цахим хуудсанд 2021 онд төсөв гүйцэтгэл цэсэнд 2 мэдээлэл, бусад цэсэнд 1 мэдээлэл нийт 3 мэдээллийг хугацаа хоцроон мэдээллэсэн байна.

Засаг даргын тамгын газар нь шилэн дансны shilendans.gov.mn цахим хуудсанд 2021 онд оруулбал зохих 128 мэдээллийг хугацаанд нь оруулсан ба сар бүр 96

мэдээлэл, улирал бүр 4 мэдээлэл оруулсан байна. Бусад цэсэнд 1 мэдээллийг хугацаа хоцроон мэдээллэсэн байна.

ДОЛОО. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ, ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Шалгалтын явцад 2021 оны касс, харилцах дансны гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгасны зэрэгцээ албан томилолтын бодолт, тооцоололт, цалин хөлсний бодолт, тогтоолт, олголт, шатахууны олголт түүний зарцуулалтыг авто машины замын хуудастай тулгаж, шатахууны хэтрэлт хэмнэлт, орлогын бүрдүүлэлт, эд хөрөнгийн тооллого тооцоо бодолт, шилэн дансны тухай хэрэгжилтийг тооцон, байгууллагын дарга, нягтлан бодогч, эд хариуцагч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

7.1. Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар 2020 он:

ИТХ: Үндсэн үйл ажиллагааны орлогын талаар: Тус Сумын ИТХ нь тайлант онд орон нутгийн төсвөөс 83,663,1 мянган төгрөгийн, төсөвт байгууллагын өөрийн орлого 250,0 мянган төгрөгийн нийт 83,913.1 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж 4,829.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Зарцуулалт: Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хурлын 2021 оны 01 сарын 15-ний өдрийн 01 дугаар тогтоолоор сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн ажлын албаны бүтэц орон тоог баталсан байна.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хурлын 2021 оны 01 сарын 15-ны өдрийн 02 дугаар тогтоолоор ИТХ-ын ажлын албаны улс төрийн болон төрийн захиргааны албан хаагчдын цалинг шинэчлэн тогтоосон байна.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хурлын 2021 оны 04 сарын 27-ны өдрийн 25 дугаар тогтоолоор ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдааны бэлтгэл хангах ажлын зардалд 112,4 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үүнд: халдвар хамгааллын ариутгалын бодис худалдан авахад 79,1 мянган төгрөг, цайны зардалд 33,3 мянган төгрөгийг, 4-р сард байгууллагын шатахууны зардалд 17,0 мянган төгрөг, бичиг хэргийн зардал 11,0 мянган төгрөг, баланк хэвлүүлэхэд 46,5 мянган төгрөгийг зарцуулсан байна. Шатахууны зардалд 68,5 мянган төгрөг, Дэвшилтэт ХХК-иар тэргүүлэгчдийн баланк хэвлүүлэхэд 11,4 мянган төгрөгийг, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хурлын 2021 оны 05 сарын 27-ны өдрийн 33 дугаар тогтоолоор Сумын ИТХ-ын 3-р хуралдааны бэлтгэл ажлыг хангах зардалд 350,5 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үүнд: Эрхт түшиг ХХК-иас ИТХ-ын хуралдааны бичиг хэргийн зардалд 83,5 мянган төгрөг, халдвар хамгааллын хэрэгсэл, ариутгалын бодис худалдан авахад 45,0 мянган төгрөг, хоолны зардалд 222,0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Принтерийн цаас татагч засуулсаны хөлс 25,0 мянган төгрөг, 7 сард Бичиг хэргийн зардалд 49,0 мянган төгрөг, Майтеч ХХК-

иас цахим индэр, утасгүй микрофон, самбар худалдан авахад 2,025.0 мянган төгрөг, Натурал текстайл групп ХХК-иас тавилга хивс худалдан авахад 828,0 мянган төгрөг, Дэвшилтэт ХХК-иар хурлын тогтоол хэвлүүлэхэд 9,5 мянган төгрөг, Монгол шуудан ХХК-иас бичиг хэргийн материал худалдан авахад 42,9 мянган төгрөг, Хаш тамга ХХК-иас хуулбар үнэн тамга хийлгэхэд 40,0 мянган төгрөг, Хил хязгааргүй ТББ-аас багийн ИНХ-ын дарга нарын гарын авлага, лавлагаа худалдан авахад 50,0 мянган төгрөг, Хангай хишиг ХХК-иас самбар, ханын фоно, төрийн сүлд худалдан авахад 2,059.0 мянган төгрөг, Сорос компьютер ХХК-иас Dell I5 нөүтбүүк худалдан авахад 2,350.0 мянган төгрөг, зөв-өнгө ХХК-иас цаас зүсэгч худалдан авахад 45,0 мянган төгрөг, Монголын нутгийн удирдлагын холбооноос тэргүүний ажилтан, соёмбо, шилдэг удирдагч зэрэг 38 тэмдэг худалдан авахад 758,0 мянган төгрөг, шатахууны зардалд 326,5 мянган төгрөг, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хурлын 2021 оны 10 сарын 19-ний өдрийн 46 дугаар тогтоолоор Сумын ИТХ-ын 4-р хуралдааны бэлтгэл ажлыг хангах зардалд 403,0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үүнд: хоолны зардалд 210,0 мянган төгрөг, хуралдааны бичиг хэргийн зардалд 202,0 мянган төгрөгийг, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хурлын 2021 оны 10 сарын 19-ний өдрийн 47 дугаар тогтоолоор Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааны бэлтгэл ажлыг хангах, оролцогчдын ариутгал халдваргүйжилтийн зардалд 291,0 мянган төгрөгийг 11 сард шатахууны зардалд 177,1 мянган төгрөг, Д.Шижирбаатараас ширээний бүтээлэг 7 ширхэг, мольт 7 ширхэгийг худалдан авахад 315,0 мянган төгрөг, принтерийн пилонк засварын зардалд 66,9 мянган төгрөг, БСБ оффис мебель ХХК-иас ИТХ-ын файлын шүүгээ, ширээ, сандал худалдан авахад 984,7 мянган төгрөг, 12 сард шатахууны зардал 266,7 мянган төгрөг, принтерийн хор худалдан авахад 44,0 мянган төгрөг, гэрлийн үнэ 23,0 мянган төгрөг, бичгийн цаас худалдан авахад 12,0 мянган төгрөг, бичиг хэргийн стандарт ном худалдан авахад 33,0 мянган төгрөг, шатахуун ызардалд 187,5 мянган төгрөг, баланк хэвлүүлэхэд 11,4 мянган төгрөг, албан томилолтын зардалд 148,0 мянган төгрөг, иргэний танхимын тохижилтын ажлын зардалд 120,0 мянган төгрөг, шатахууны зардал 104,0 мянган төгрөг, бичиг хэргийн зардал 78,9 мянган төгрөг, даатгалын төлбөр 46,2 мянган төгрөг, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хурлын 2021 оны 11 сарын 25-ны өдрийн 50 дугаар тогтоолоор МУ-ын Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ойг тохиолдуулан УИХ-ын дарга Г.Занданшатарын ивээл дор зохион байгуулагдсан “Сумын аварга” шалгаруулах шатрын тэмцээний зардалд 132,0 мянган төгрөг зарцуулсан байна. Үүнд: тэмцээний шагналд 90,0 мянган төгрөг, жааз худалдан авахад 42,0 мянган төгрөг, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хурлын 2021 оны 12 сарын 17-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор Гэмт хэрэг зөрчлөөс

урьдчилан сэргийлэх, иргэдийг соён гэгээрүүлэх зорилгоор хийгдсэн самбарын үнэ 440,0 мянган төгрөг, иргэдэд тараах гарын авлага брошур хэвлүүлэх зардалд 109,2 мянган төгрөг нийт 549,2 мянган төгрөг, и Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хурлын 2021 оны 12 сарын 22-ны өдрийн 71 дугаар тогтоолоор Сумын ИТХ-ын үе үеийн төлөөлөгчдийн цомог хийлгэх, утасны жагсаалт хийлгэх зардалд 4,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Тэтгэмж урамшууллын талаар:

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хурлын 2021 оны 03 сарын 16-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор Багийн ИНХ-ын дарга нарын 1 дүгээр улирлын урамшуулалд 2,154.1 мянган төгрөгийг олгосон байна.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хурлын 2021 оны 03 сарын 16-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Н.Хандмаад Төрийн албаны салбар зөвлөлөөс Ахлах түшмэлийн “Гутгаар” зэрэг дэв олгосон тул зэрэг дэвийн нэмэгдлийг үндсэн цалингаас 28 хувиар тооцож олгохоор шийдвэрлэсэн байна.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын 2021 оны 12 сарын 15-ны өдрийн Б/03 дугаар тушаалаар Сумдын ИТХ-ын ажлын албаны ажилтаны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт ажлын дүнгээр маш сайн үнэлгээ авсан тул үндсэн цалингийн 40 хувиар тооцон 234.2 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хурлын 2021 оны 04 сарын 30-ны өдрийн 40 дүгээр тогтоолоор Сумын ИТХ-ын дарга Н.Баяртайд хүндэтгэл үзүүлэхэд 100,0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2021 оны 07 сарын 08-ны өдрийн Б/01 дүгээр захирамжаар Сумдын ИТХ-ын тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт ажлын дүнгээр маш сайн үнэлгээ авсан тул үндсэн цалингийн 40 хувиар тооцон 377,4 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2021 оны 12 сарын 15-ны өдрийн Б/02 дугаар захирамжаар Сумдын ИТХ-ын тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт ажлын дүнгээр маш сайн үнэлгээ авсан тул үндсэн цалингийн 40 хувиар тооцон 377,4 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хурлын 2021 оны 10 сарын 19-ний өдрийн 45 дугаар тогтоолоор сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 1,2,3 дугаар улирлын урамшуулал 950,0 мянган төгрөг, багийн ИНХ-ын дарга нарын 2 дугаар улирлын урамшуулалд 3,273.0 мянган төгрөгийг олгосон байна.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хурлын 2021 оны 11 сарын 25-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 4 дүгээр улирлын урамшуулал 350,0 мянган төгрөг, багийн ИНХ-ын дарга нарын 3 дугаар улирлын урамшуулалд 2,170.9 мянган төгрөгийг олгосон байна.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хурлын 2021 оны 12 сарын 06-ны өдрийн 58 дугаар тогтоолоор багийн ИНХ-ын дарга нарын 4 дүгээр улирлын урамшуулалд 2,170.9 мянган төгрөгийг олгосон байна. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хурлын 2021 оны 12 сарын 14-ний өдрийн 64 дүгээр тогтоолоор аймгийн ИТХ-ын “Хүндэт жуух”, “Баярын бичиг”-ээр шагнагдсан сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Н.Хандмаа, ИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгч С.Гиваапил, Г.Готовдорж, Г.Отгонхүү нарт шагналын дагалдах мөнгөн урамшуулалд 300,0 мянган төгрөгийг олгосон байна.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын 2021 оны 11 сарын 29-ний өдрийн Б/02 дугаар тушаалаар ИТХ-ын ажлын албаны ажилтан Т.Сувданчимэгийн нөхөр нас барсан учир 150,0 мянган төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийг олгосон байна.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хурлын 2021 оны 12 сарын 14-ний өдрийн 63 дугаар тогтоолоор Сумын ИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгч С.Батхуягын 50 насны ойд 50,0 мянган төгрөгийн тэтгэмжийг олгосон байна.

Нэмэлт санхүүжилт:

Баянгол багийн иргэн Д.Баатараас Сумын ИТХ-ын иргэний танхимыг тохижуулахад 250,0 мянган төгрөгийг хандивласан байна. Иргэн Д.Баатараас хандивласан 250,0 мянган төгрөгөөр Хангайн хишиг ХХК-иас төрийн сүлд 100,0 мянган төгрөгөөр, самбар 150,0 мянган төгрөгөөр худалдан авсан байна.

ЗДТГ: Үндсэн үйл ажиллагааны орлогын талаар: Сумын Засаг даргын тамгын газар нь тайлант онд төсвийн захирагчийн 6 чиглэлийн арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 376,018.7 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 402,215.1 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, 2,991.0 мянган төгрөгийн өөрийн орлогыг шатсан барилгын материалыг хоёрдагч түүхий эд болгож борлуулсны орлого болох зөрчил гаргаад хураагдсан автомашиныг борлуулсны орлого, урсгал үйл ажиллагаанд 382,643.7 мянган төгрөгийг зарцуулж, 22,562.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 382,643.7 мянган төгрөг буюу 93.9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 11,663.2 мянган төгрөгөөр буюу 5.1 хувиар, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 1,228.7 мянган

төгрөгөөр буюу 4.3 хувиар, байр ашиглалттай холбоотой зардал 308.5 мянган төгрөгөөр буюу 1.1 хувиар, эд хогшил, урсгал засварын зардал 39,084.9 мянган төгрөгөөр буюу 71.2 хувиар, хангамж, бараа материалын зардал 1,844.5 мянган төгрөгөөр буюу 10.4 хувиар, томилолт зочины зардал 464.0 мянган төгрөгөөр буюу 13.3 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн, ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 2,433.6 мянган төгрөгөөр буюу 50.4 хувиар, бараа үйлчилгээний бусад зардал 8,505.2 мянган төгрөг буюу 21.8 хувиар тус тус хэмнэсэн байна.

Зарцуулалт: Могод сумын Засаг даргын тамгын газрын даргын 2021 оны 01 сарын 01-ний өдрийн А/01 тоот тушаалаар байгууллагын бүтэц орон тоог баталсан байна.

Могод сумын Засаг даргын тамгын газрын даргын 2021 оны 01 сарын 01-ний өдрийн Б/02 тоот тушаалаар байгууллагын албан хаагчдын цалинг шинэчлэн тогтоосон байна. 2021 оны 02 сарын 18-нд Булган аймгийн Төрийн аудитад санхүүгийн тайлан тушаах ажлаарсанхүүгийн албаны 4 албан хаагчид 898,0 мянган төгрөг, 2020 оны цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийн тайлан тушаахад 2 албан тушаалтанд 92,0 мянган төгрөгийн томилолтыг олгосон байна. Сорос компьютер ХХК-иас Dell суурин компьютер, Dell I5 2 ширхэг, Dell нөүтбүүк худалдан авахад 9,664.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. БСБ оффис мебель ХХК-иас Ride-wt 2 ширхэг, тумбочки 1 ширхэгийг худалдан авахад 867,2 мянган төгрөгийг, хурлын ширээ 25 ширхэг сандал худалдан авахад 8,017.3 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна. Есөн Оюу Трейд ХХК-иас насос, тоос сорогч, аппарат худалдан авахад 759,0 мянган төгрөг зарцуулсан. Би Си Ти ХХК-иас HP135a принтер 4 ширхэгийг худалдан авахад 2,046.0 мянган төгрөг, Хангай Хишиг ХХК-иас Засаг дарга болон Тамгын газрын дарга нарт төрийн сүлд худалдан авахад 198,0 мянган төгрөг, самбар худалдан авахад 275,0 мянган төгрөг, Гурванцагийн өнгө ХХК-иас мэдээллийн самбар, өрөөний хаяг, хамт олны самбар худалдан авахад 3,260.4 мянган төгрөг, Мокмагнет ХХК-иас гүйдэг хаалга шкаф худалдан авахад 290,0 мянган төгрөг, Л.Энх-Амгалангаас гэрэлтүүлэгийн цагийн релейны үнэ 180,0 мянган төгрөг, Төгс-Үчинбэр ХХК-иас тавилга, оффис сандал худалдан авахад 512,6 мянган төгрөг, Эрхт түшиг ХХК-иас угтах ширээ суурин компьютэр худалдан авахад 630,0 мянган төгрөг, БСБ оффис мебель ХХК-иас оффис сандал, төмөр шкаф, модон ширээ худалдан авахад 5,935.0 мянган төгрөгийг, Цацрах хурд интернэшилээс хятад рек, булан худалдан авахад 709,5 мянган төгрөгийг зарцуулсан. Дэжидээс бүргэд хаалга худалдан авахад 675,0 мянган төгрөг, Гантуяагаас тавилга, шатны хаалт худалдан авахад 570,0 мянган төгрөг, Анхтуяагаас гэрэлтүүлэгийн пускатель худалдан авахад 115,5 мянган төгрөг, Талын салхи ХХК-д принтер засварын үнэ 40,0 мянган төгрөг, Л.Отгончимэгээс цоожны гол

болон бусад материал худалдан авахад 212,4 мянган төгрөг, Гурав ди ханын цаг худалдан аюахад 89,0 мянган төгрөг, Эрдэнийн шаглаа ХХК-иас зочид буудлын ор 3 ширхэгийг худалдан авахад 1,386.0 мянган төгрөг, Натурал текстайл ХХК-иас тавилга хивс худалдан авахад 1,899.9 мянган төгрөг, Эрхт дулаан ХХК-иас зочид буудлын модон ширээ худалдан авахад 485,0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

12 сарын цагийн бүртгэл байхгүй анхан шатны баримтын бүрдэл дутуу

ХАА-н мэргэжилтэн Ш.Мөнхбаатарын Булган аймагт 2 хоног ажилласан албан томилолтын тооцоог хийхдээ Засаг даргын гарын үсэг тамга тэмдэггүй байхад албан томилолтыг бодож олгосон.

Эрхт түшиг ХХК-иас 10 ширхэг халаалтын пар худалдан авахад 2,100.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Л.Отгончимэгийн 5277144189 тоот дансанд Бүтээмж чанарыг сайжруулах жилийн аяны санхүүжилт 500,0 мянган төгрөг, тус байгууллагын ахмад ажилтан Хууль эрх зүйн мэргэжилтэн Ш.Нарантуяа, ахмад настан Л.Эрдэнэцэцэг нарт нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлж, түлшний мод худалдан авахад нэг удаагийн буцалтгүй тусламж 900,0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Эрхт дулаан ХХК-иас төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын хувцас худалдан авахад 300,0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Цалин урамшууллын талаар: Булган аймгийн Засаг даргын 2021 оны 01 сарын 04-ний өдрийн Б/01 дугаар захирамжаар Могод сумын Засаг дарга Ц.Баярсайханд Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахалтай тэмцэх ажилд санаачлага гарган ажилласан тул нэг сарын үндсэн цалинг 1,5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг олгосон байна. Могод сумын Засаг даргын тамгын газрын даргын 2021 оны 01 сарын 04-ний өдрийн Б/04 тоот тушаалаар сумын Засаг дарга Ц.Баярсайхан нь Улаанбаатар хотод нарийн мэргэжлийн эмчийн шинжилгээ оношлогоонд явахад нэг удаагийн буцалтгүй тусламж 100,0 мянган төгрөгийг олгосон байна.

Могод сумын Засаг даргын тамгын газрын даргын 2021 оны 12 сарын 17-ний өдрийн Б/14 тоот тушаалаар албан хаагчдын 2021 оны жилийн эцсийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээний үүргийн биелэлтийг 25-40 хувиар үнэлэн 9 албан хаагчид 2,012.5 мянган төгрөгийг олгосон байна. 11 сарын 4-ний өдрийн №00167 тоот төлбөрийн хүсэлтээр О.Эрдэнэчимэгт өндөр насны тэтгэвэр тогтоолгоход олгосон нэг удаагийн тэтгэмжийн үлдэгдэл 551597 төгрөгийг олгосон байна. Могод сумын Засаг даргын 2021 оны 12 сарын 16-ны өдрийн Б/30 дугаар захирамжаар Засаг даргын тамгын газрын дарга Х.Мөнх-Алтайгийн жилийн эцсийн ажлын үр дүн төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээг харгалзан нийгмийн асуудлыг нь

шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж үндсэн цалингийн 40 хувиар үнэлэн 377,4 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна.

Могод сумын Засаг даргын 2021 оны 12 сарын 16-ны өдрийн Б/30 дугаар захирамжаар Засаг даргын орлогч дарга Г.Амартүвшингийн жилийн эцсийн ажлын үр дүн төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээг харгалзан нийгмийн асуудлыг нь шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж үндсэн цалингийн 40 хувиар үнэлэн 377,4 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна.

Могод сумын Засаг даргын 2021 оны 07 сарын 26-ны өдрийн Б/24 дүгээр захирамжаар Засаг даргын тамгын газрын дарга Х.Мөнх-Алтайгийн хагас жилийн ажлын үр дүнг үнэлэн Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлын хүнд цаг үеийн ажлын ачааллыг харгалзан нийгмийн асуудлыг нь шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж үндсэн цалингийн 40 хувиар үнэлэн 356,0 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна.

Могод сумын Засаг даргын тамгын газрын даргын 2021 оны 07 сарын 19-ний өдрийн Б/09 тоот тушаалаар албан хаагчдын 2021 оны хагас жилийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээний үүргийн биелэлтийг 40 хувиар үнэлэн 13 албан хаагчид 3,039.4 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг олгосон байна.

Засаг даргын тамгын газрын даргын 2021 оны 10 сарын 01-ний өдрийн Б/11 тоот тушаалаар жолооч Ц.Золбаярт байгууллагын дулаан халаалт, цэвэр бохир усны шугамын сантехникийн үйлчилгээ, арчилгааны слесарийн ажлыг халаалтын улиралд хавсран гүйцэтгүүлж, ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг үндсэн цалингийн 10 хувиар тооцон олгох тушаал гаргасан байна. Могод сумын Засаг даргын 2021 оны 01 сарын 28-ны өдрийн Б/04 дүгээр захирамжаар Засаг даргын тамгын газрын дарга О.Эрдэнэчимэгт Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахалтай тэмцэх ажилд санаачлага гарган ажилласан тул нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшууллыг олгосон байна.

Могод сумын Засаг даргын 2021 оны 11 сарын 01-ний өдрийн Б/25 дугаар захирамжаар Баянгол багийн Засаг дарга Х.Шаарийбуугийн 2021 оны ажлын гүйцэтгэлийн үр дүн, Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахалтай тэмцэх, сэргийлэх арга хэмжээг багийн нутаг дэвсгэрийн хэмжээнд оновчтой зохион байгуулж, удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг шуурхай гүйцэтгэн иргэдийг эрсдлээс хамгаалах төрийн үйлчилгээг сайжруулахад шаардлагатай хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэх, нийгмийн хариуцлагын хүрээнд хандив, хөрөнгө оруулалтыг бүрдүүлэхэд идэвхи санаачлага гаргаж ажилласан тул нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшууллыг олгосон байна.

Могод сумын Засаг даргын 2021 оны 02 сарын 01-ний өдрийн Б/07 дугаар захирамжаар Х.Мөнх-Алтайг Засаг даргын тамгын газрын даргын үүрэг гүйцэтгэгчээр томилж, цалинг Т39-3 шатлалаар 943597 төгрөгөөр тогтоож зэрэг дэвийн нэмэгдэл 18 хувь, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 10 хувиар тооцож олгосон байна.

Нэмэлт санхүүжилтийн талаар:

Нэмэлт санхүүжилтийн орлого нь дараах эх үүсвэрээс бүрдсэн байна. Үүнд:

- Ковид-19 цар тахалтай холбоотойгоор урьдчилан сэргийлэх зардалд 5,000.0 мянган төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас,
- Нэр бүхий 10 иргэнээс 1,384.0 мянган төгрөгийг хандив,
- Төрөөс хариуцах цэвэр бохир усны төлбөрийн хөнгөлөлт 10,116.8 мянган төгрөгийг Булган мээж ХХК-иас,
- Хамтарсан багийн сургалтын зардалд 300.0 мянган төгрөгийг аймгийн ИТХ-аас,
- Хагас жилийн мал тооллогын зардалд 838.0 мянган төгрөг, мэдээлэл цуглуулах судалгааны зардал 50.0 мянган төгрөгийг нийт 878.0 мянган төгрөгийг Статистикийн хэлтсээс,
- Нэр бүхий 10 өрхийн хүнсний дэмжлэгт 500.0 мянган төгрөгийг ХГБХЗХөгжлийн газраас,
- Огтоно устгалын зардалд 5,100.0 мянган төгрөгийг ХХААГ-аас,
- Өмнөх оны жилийн эцсийн нэмэлт санхүүжилтийн дансны авлага 5,365.4 мянган төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогоос,
- ногоон байгууламжийн зардалд 5,000.0 төгрөг төгрөгийг Булган аймгийн БОАЖ-ын газраас тус тус санхүүжсэн байна..

Зарцуулалт: Нэмэлт санхүүжилтийн талаар:

Могод сумын Засаг даргын тамгын газрын даргын 2021 оны 2 сарын 04-ний өдрийн А/04 тоот тушаалаар 5,365,4 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулахаар шийпвэрлэсэн байна. Үүнээс: ЗДТГ нь 2021 оны 02 сарын 5-нд Пи Эс Си ХХК-иас дрэйгер алкотест 6820 буюу согтолт хэмжигч багажыг 2,921.6 мянган төгрөгөөр, Элмонте ХХК-иас нүүр хуруугаар цаг бүртгэгчийг 418,0 мянган төгрөгөөр худалдан авсан байна. Тамгын газрын даргын 02 сарын 08-ны өдрийн А/03 тоот тушаалаар Булган Мээж ХХК-иас ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд орж ирсэн төрөөс дааж байгаа цэвэр усны хөнгөлөлтийн орлого 910,0 мянган төгрөгөөс доод толгойн худгын усны төлбөрт 260,0 мянган төгрөгийг, дээд толгойн арын худагын усны төлбөрт 250,0 мянган төгрөг, хойд хорооны төв худагын усны төлбөрт 400,0 мянган төгрөгийг, Тамгын газрын даргын 03 сарын 01-ний өдрийн А/06 тоот тушаалаар төрөөс дааж байгаа цэвэр усны хөнгөлөлтийн орлого 910,0 мянган

төгрөгөөс доод толгойн худгын усны төлбөрт 260,0 мянган төгрөгийг, дээд толгойн арын худагын усны төлбөрт 250,0 мянган төгрөг, хойд хорооны төв худагын усны төлбөрт 400,0 мянган төгрөгийг, Тамгын газрын даргын 04 сарын 07-ны өдрийн А/11 тоот тушаалаар төрөөс дааж байгаа цэвэр усны хөнгөлөлтийн орлого 980,0 мянган төгрөгөөс доод толгойн худгын усны төлбөрт 330,0 мянган төгрөгийг, дээд толгойн арын худагын усны төлбөрт 250,0 мянган төгрөг, хойд хорооны төв худагын усны төлбөрт 400,0 мянган төгрөг, 5 сарын төрөөс дааж байгаа цэвэр усны хөнгөлөлтийн орлого 1,790.0 мянган төгрөгөөс доод толгойн худгын усны төлбөрт 600,0 мянган төгрөгийг, дээд толгойн арын худагын усны төлбөрт 620,0 мянган төгрөг, хойд хорооны төв худагын усны төлбөрт 570,0 мянган төгрөг, 6 сарын төрөөс дааж байгаа цэвэр усны хөнгөлөлтийн орлого 976,0 мянган төгрөгөөс доод толгойн худгын усны төлбөрт 326,0 мянган төгрөгийг, дээд толгойн арын худагын усны төлбөрт 250,0 мянган төгрөг, хойд хорооны төв худагын усны төлбөрт 400,0 мянган төгрөг, 9 сарын төрөөс дааж байгаа цэвэр усны хөнгөлөлтийн орлого 1,166.4 мянган төгрөгөөс доод толгойн худгын усны төлбөрт 376,0 мянган төгрөгийг, дээд толгойн арын худагын усны төлбөрт 250,0 мянган төгрөг, хойд хорооны төв худагын усны төлбөрт 540,4 мянган төгрөг, 11 сарын төрөөс дааж байгаа цэвэр усны хөнгөлөлтийн орлого 2,080.4 мянган төгрөгөөс доод толгойн худгын усны төлбөрт 711,4 мянган төгрөгийг, дээд толгойн арын худагын усны төлбөрт 450,0 мянган төгрөг, хойд хорооны төв худагын усны төлбөрт 919,0 мянган төгрөгийг олгосон байна. Булган аймгийн Засаг даргын 2021 оны 02 сарын 09-ний өдрийн А/60 дугаар захирамжаар Коронавируст цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, хяналтын цэгийн үйл ажиллагаанд шаардагдах дэмжлэгт 5,000.0 мянган төгрөгийг олгосон байна.

Могод сумын Засаг даргын тамгын газрын даргын 2021 оны 03 сарын 01-ний өдрийн А/05 тоот тушаалаар урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 5,000.0 мянган төгрөгийг зарцуулахаар шийдвэрлэсэн. Үүнд: Хяналтын постуудын шатахууны зардалд 688,0 мянган төгрөг, 1,2,3,4,5-р постын түлшний зардалд 663,0 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 81,5 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 144,6 мянган төгрөг, ариутгал халдваргүйжилтийн зардалд 509,0 мянган төгрөг, шуурхай штабын бичиг хэргийн зардалд 58,2 мянган төгрөг, шатахууны зардалд 2,181.8 мянган төгрөг, бусад зардал /гэрэл, бээлий, уртасгагч/-д 206,5 мянган төгрөг, постны албан хаагч нарын хамгааллын хэрэгсэл маск худалдан авахад 180,0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тамгын даргын 2021 оны 06 сарын 28-ны өдрийн А/18 тоот тушаалаар 202 оны хагас жилийн мал тооллогын хүрээнд стастикийн газраас ирүүлсэн санхүүжилтийг малын түүвэр тооллогын зардалд зарцуулсан байна. Үүнд: хагас жилийн мал

тооллогын ажлын шатахууны зардалд 394,0 мянган төгрөг, тооллогын урамшуулалд 444,0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан “Эрсдлийг бууруулъя” сарын аяны хүрээнд эмзэг бүлгийн өрхөд 303,5 мянган төгрөгийн хүнсний бараа, эмзэг бүлгийн 15 иргэнд маск болон дархлаа дэмжих витамин худалдан авахад 195,0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тамгын газрын даргын 2021 оны 12 сарын 06-ны өдрийн А/25 тоот тушаалаар Булган аймгийн Статистикийн хэлтсээс ирүүлсэн мэдээлэл судалгаа цуглуулах зардал 50,0 мянган төгрөгийг статистикийн мэдээлэл цуглуулах судалгааны хөлсөнд 50,0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тамгын газрын даргын 2021 оны 12 сарын 06-ны өдрийн А/25 тоот тушаалаар хамтарсан багийн сургалт зохион байгуулахад 300,0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Хамтарсан багийн сургалтанд хамрагдах албан хаагчдыг Орхон сум хүргэх шатахууны зардалд 115,0 мянган төгрөг, хоолны зардалд 179,1 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Тамгын газрын даргын 2021 оны 12 сарын 06-ны өдрийн А/27 тоот тушаалаар бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлын зардалд 3,600.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үүнд: Огтоно устгалын ариутгал болон бусад материалын зардалд 912,0 мянган төгрөг, шатахууны зардалд 1,742.6 мянган төгрөг, хоолны зардалд 25,2 мянган төгрөг, огтоно устгалын шувууны суудлын үнэ 504,0 мянган төгрөг, огтоно устгалын тайлан хүргэх албан томилолтын зардалд 140,0 мянган төгрөг, Тамгын газрын даргын 2021 оны 12 сарын 24-ний өдрийн А/31 тоот тушаалаар бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлын зардалд 1,500.0 мянган төгрөгийг зарцуулахаар шийдвэрлэж, огтоно устгалын ажилчдын урамшуулалд 1,225.1 мянган төгрөг, ажилчдын ХХОАТ-т 135,0 мянган төгрөг, НДШ-д 415,8 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Тамгын газрын даргын 2021 оны 12 сарын 06-ны өдрийн А/27 тоот тушаалаар ногоон байгууламжыг нэмэгдүүлэх арга хэмжээний зардалд 5,000.0 мянган төгрөгийг зөрцуулахаар шийдвэрлэсэн байна. Үүнд: хогоон байгууламжын мод болон цэцэгний үрийг Маргад орхон ХХК-иас худалдан авахад 3,790.0 мянган төгрөг, ногоон байгууламжын хашааны үнэ, шон, бусад материалын зардалд 1,210.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

7.2 Өглөг, авлагын талаар: ИТХ нь 2021 онд өглөг, авлагагүй тайлан гаргасан байна. ЗДТГ нь 2021 оны эцэст бусад байгууллагаас авах авлага тооцооны 4,798.8 мянган төгрөгийн авлагатай тайлагнасан байна.

7.3 Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт: ИТХ-ын ажлын албаны үйл ажиллагаанд ашиглах нөтбүкийг 2.350,0 мянган төгрөг, тавилга эд хогшил худалдан

авахад 4.842,7 мянган төгрөг, программ хангамж 1,000.0 мянган төгрөг, нийт 8,192.7 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авсан байна.

Оны эцэст машин тоног төхөөрөмж 5,719.7 мянган төгрөг, тавилга эд хогшил 7,991.8 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө 1,121.7 мянган төгрөг, программ хангамж 899,9 мянган төгрөг нийт 15,733.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэйгээр тайлан балансад тусгасан байна.

7.3 Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт: ЗДТГ нь 15,923.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 26,714.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил 2,100.0 мянган төгрөгийн программ хангамж нийт 44,737.6 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 73,032.0 мянган төгрөгийн барилга байгууламж, 25,745.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 6,837.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 300,0 мянган төгрөгийн программ хангамж нийт 105,914.0 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгээс хасаж, оны эцэст барилга байгууламж 1,337,980.3 мянган төгрөг, авто тээврийн хэрэгсэл 51,380.8 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 90,104.4 мянган төгрөг, тавилга эд хогшил 48,127.2 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө 20,333.4 мянган төгрөг, программ хангамж 1,750.0 мянган төгрөг, бусад биет бус хөрөнгө 26,334.0 мянган төгрөг нийт 1,576,010.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэйгээр тайлан балансад тусгасан байна.

7.4. Бараа материалын хөдлөл өөрчлөлт 2020 он:

ИТХ: 2021 онд бичиг хэргийн зардал 545,7 мянган төгрөг, аж ахуйн материал 1,007.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант хугацаанд бичиг хэргийн материал 13,96.8 мянган төгрөг, түлш шатах, тослох материал 1,174.3 мянган төгрөг, аж ахуйн материал 1,487.0 мянган төгрөг, бусад хангамжийн материал 2,104.0 мянган төгрөг нийт 8,734.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 2,015.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 8,271.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

ЗДТГ: Тайлант оны эхний бараа материал дээр төсвийн хөрөнгөөр 52,928.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, нийт 46,693.4 мянган төгрөгний бараа материалыг зарлагдаж, жилийн эцэст 59,261.6 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

НАЙМ. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ЗӨРЧИГДСӨН ХУУЛЬ, ТОГТООМЖ

ИТХ, ЗДТГ:

1. Албан томилолтоор ажилласан албан хаагч нарт албан томилолтын зардлыг олгохдоо анхан шатны баримтын бүрдэл дутуу материалаар /томилолтын ирсэн, явсан хугацааг хаагаагүй, даргын гарын үсэг тамга тэмдэг дарагдаагүй/ бодож олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь

/Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно/ заасныг зөрчсөн.

2. Жилийн эцэст харилцагч байгууллагуудтайгаа тооцоо нийлсэн акт үйлдээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4. /эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах/ заалтыг хэрэгжүүлээгүй.

ЕС. АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА, ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ

Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 1 актаар 117,4 мянган төгрөгийн төлбөр тогтоож, нягтлан бодогч, нярав нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

АРАВ. ДҮГНЭЛТ

Могод сумын ИТХ, Засаг даргын тамгын газрын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар анхан шатны баримтын бүрдэл дутуу, даргын гарын үсэг, тамгагүй албан томилолтын хуудсаар гүйлгээ хийсэн, ирсэн явсан хугацааг тавиагүй байхад албан томилолтыг бодож олгосон, цагийн балансыг гаргаж баримтанд хавсаргаагүй, тооцоо нийлсэн акт үйлдээгүй зэрэг зөрчлүүд арилахгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, 13.6, 13.7 дахь заалтууд, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалыг хэрэгжүүлээгүй, анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй, байгууллагын дотооддоо тавих хяналт сул байна гэж дүгнэлээ.

АРВАН НЭГ. ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хуулиуд болон холбогдох тушаал, дүрэм, журам, зааврыг мөрдөж ажиллах.

Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоодын хяналт шалгалтыг тогтмол хийж, гүйцэтгэлийг хянан баримтжуулж, санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх.

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх.

Шилэн дансны тухай хууль, журам, захирамж, шийдвэрүүдийг хэрэгжүүлж биелэлтийг тооцож, хариуг улирал тутам албан бичгээр ирүүлэх.

Илэрсэн зөрчлүүдийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх талаар анхааран тодорхой ажил зохион байгуулж, акт, албан шаардлагын биелэлтийг албан тоотоор хүргүүлэх.

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

А.АНХБАЯР

